

**Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай  
холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам**

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Энэхүү журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох үндэсний стандартад нийцүүлэн гэрчилгээжүүлэх ажлыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.
- 1.3 Иргэн, хуулийн этгээд нь төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэлтэд хамруулах, тэдгээрт хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм, нормативын баримт бичгээр тавигдах нөхцөл, шаардлагыг хангах үүрэгтэй.
- 1.4 Энэ журамд заасан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
  - 1.4.1 “төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах” гэж хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгөд хохирол учруулах, осол, сүйрлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төмөр замын хөдөлгөөнийг зохион байгуулж буй үйл ажиллагааны цогцыг,
  - 1.4.2 “гэрчилгээ” гэж объект, үйл ажиллагаа нь төмөр замын тээврийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлага хангасныг нотолж олгосон баримт бичгийг,
  - 1.4.3 “гэрчилгээ эзэмшигч” гэж энэ журмын дагуу гэрчилгээжүүлэх нөхцөл, шаардлагыг хангаж, объект, үйл ажиллагааны гэрчилгээ авсан иргэн, хуулийн этгээдийг,
  - 1.4.4 “гэрчилгээжүүлэлт” гэж төмөр замын объект, үйл ажиллагаа нь тээврийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлага хангасан эсэхийг тогтоож, гэрчилгээ олгох үйл ажиллагааг,
  - 1.4.5 “норм, нормативын баримт бичиг” гэж нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, байгаль орчин, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах зорилгоор үйлдвэрийн бүтээгдэхүүн, объект, үйл ажиллагаа, түүнд хамаарах нийтлэг шаардлага тодорхойлсон стандарт, дүрэм, журмыг,
  - 1.4.6 “гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлага” гэж энэ журмын 1.5-д заасан зорилгын хүрээнд төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой объект, үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм, нормативын баримт бичгээр тавигдах шалгуурыг.

1.5 Гэрчилгээжүүлэлтийн зорилго:

- 1.5.1 Төмөр замын тээврийн салбарт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор сүйрэл, осол, гологдол гарахгүй байх техник, технологийн нөхцөлийг бүрдүүлж байгаа эсэхийг хянан шалгах, үнэлэлт дүгнэлт өгөх.
  - 1.5.2 Төмөр замын тээврийн салбарт дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, тээх, нэвтрүүлэх чадвар, өрсөлдөөний нөхцөл байдлыг тодорхойлох.
  - 1.5.3 Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал болон эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх.
- 1.6 Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь төмөр замын аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлтэд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд гэрээ байгуулж хамтран ажиллана.
- 1.7 Гэрчилгээжүүлэх үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу, ил тод, нээлттэй, шуурхай байх зарчмыг баримтална.

**Хоёр. Гэрчилгээжүүлэх объект, үйл ажиллагаа**

2.1 Дараах объектыг гэрчилгээжүүлнэ.

2.1.1 Суурь бүтцийн чиглэлээр:

2.1.1.1 Нийтийн хэрэглээний зам, талбай.

2.1.1.2 Дагнасан хэрэглээний зам, талбай.

2.1.1.3 Өртөө, зэрлэг /төмөр замын дохиолол, холбооны байгууламж/.

2.1.2 Хөдлөх бүрэлдэхүүний чиглэлээр:

2.1.2.1 Бүх төрлийн зүтгүүр.

2.1.2.2 Бүх төрлийн ачааны вагон.

2.1.2.3 Бүх төрлийн зорчигчийн вагон.

2.1.2.4 Сэргээн босгох, гал унтраах галт тэрэг.

2.1.2.5 Зам засвар, арчлалт, оношлогоо, хэмжилт хийх бүх төрлийн машин механизм.

2.2 Дараах үйл ажиллагааг гэрчилгээжүүлнэ.

2.2.1 Дагнасан хэрэглээний зам, талбай барих.

2.2.2 Дагнасан хэрэглээний зам, талбайд ачих, буулгах үйл ажиллагаа гүйцэтгэх.

- 2.2.3 Төмөр замын тээвэр зуучлал.
- 2.2.4 Дагнасан хэрэглээний замд сэлгээний ажил гүйцэтгэх.
- 2.2.5 Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ.
- 2.2.6 Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ.
- 2.2.7 Хатуу тооцоот багаж, хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа.
- 2.2.8 Төмөр замын зураг төсөл боловсруулах.
- 2.2.9 Дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар, арчлалт.
- 2.2.10 Төмөр замын дохиолол, холбооны байгууламжийн засвар, техникийн үйлчилгээ.

### **Гурав. Гэрчилгээжүүлэлтийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаа**

- 3.1 Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - 3.1.1 Гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг боловсруулж батлах.
  - 3.1.2 Гэрчилгээ бүхий объект, үйл ажиллагаа нь гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан шалгах, гэрчилгээ олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох.
  - 3.1.3 Гадаад улсын гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон гэрчилгээг хүлээн зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх.
  - 3.1.4 Төмөр замын тээврийн объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх асуудлаар бусад улсын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах.
  - 3.1.5 Энэ журмын 1.5-д заасан зорилгод нийцүүлэн гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагаа, түүний төрөл ангилал, тавигдах нөхцөл, шаардлагыг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх.
  - 3.1.6 Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх.
  - 3.1.7 Гэрчилгээжүүлэлтийг хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу явуулж байгаа эсэхийг шалгаж, шаардлагатай тохиолдолд гаргасан дүгнэлт, шийдвэрийг хүчингүй болгох.
  - 3.1.8 Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьж, биелэлтийг хангуулах.

## **Дөрөв. Гэрчилгээ хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх**

4.1 Гэрчилгээ авах тухай хүсэлт гаргахдаа дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ.

4.1.1 Объектын гэрчилгээ:

4.1.1.1 Зохих журмын дагуу гаргасан өргөдөл.

4.1.1.2 Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар.

4.1.1.3 Гэрчилгээжүүлэх объектын танилцуулга.

4.1.1.4 Тухайн объектын гарал үүсэл, тохирлын эсхүл чанарын гэрчилгээ, паспорт, засвар өөрчлөлтийн бүртгэл, ашиглалтын заавар, техникийн зураг, схем.

4.1.1.5 Объект нь гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичиг.

4.1.1.6 Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмших зөвшөөрлийн гэрчилгээ, өмч хувьчлалын шийдвэр, худалдах, худалдан авах гэрээ, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, узуфрукт эрх, түрээсийн гэрээ болон бусад шаардлагатай баримт бичиг.

4.1.2 Үйл ажиллагааны гэрчилгээ:

4.1.2.1 Зохих журмын дагуу гаргасан албан хүсэлт.

4.1.2.2 Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар.

4.1.2.3 Эрхлэх үйл ажиллагааны танилцуулга.

4.1.2.4 Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт болон техникийн тодорхойлолт, ажлын байрны талаарх мэдээлэл, технологийн горим, заавар.

4.1.2.5 Журмын 4.5.2.4-т заасан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ажлын байрыг бусад хуулийн этгээдээс түрээсээр авч ашигладаг бол энэ тухай гэрээний хуулбар.

4.1.2.6 Холбогдох үйл ажиллагааны төрөл, суурь нөхцөл, шаардлагад нийцсэн мэргэжлийн ажилтнуудын мэргэжлийн диплом, мэргэшлийн гэрчилгээ, батламжийн нотариатаар баталгаажуулсан хуулбар, тэдгээрийн туршлага, ур чадварын тухай мэдээлэл.

- 4.1.2.7 Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нь тухайн гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон холбогдох үйл ажиллагааны зөвшөөрлийн гэрчилгээг хүсэлтэд хавсаргах.
  - 4.1.2.8 Харьяалах татварын байгууллагын тодорхойлолтыг эх хувиар нь хавсаргах.
  - 4.1.2.9 Холбогдох үйл ажиллагааны дагуу хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлснийг баталгаажуулах харъяалах нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолтыг эх хувиар нь хавсаргах.
  - 4.1.2.10 Холбогдох үйл ажиллагааны дагуу хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын журмын хавсралтад заасан инженер техникийн болон бусад ажиллагсдын нийгмийн даатгалын дэвтэр (тушаал, шимтгэл төлсөн хуудсыг нотариатаар баталгаажуулсан байх).
  - 4.1.2.11 Үйл ажиллагааны хариуцлагын даатгалын баталгаа эсхүл төлбөрийн баримтын эх хувь.
  - 4.1.2.12 Үйл ажиллагаа нь энэхүү журмын хавсралтад заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичиг.
- 4.2 Гэрчилгээжүүлэх төмөр замын объект, үйл ажиллагаа нь дараах нөхцөлийг хангасан байхаас гадна объект, үйл ажиллагааны төрөл, онцлогоос шалтгаалан энэхүү журмын хавсралтад заасан нөхцөл шаардлагыг хангавал зохино.
- 4.2.1 Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, стандарт, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн шаардлага, бусад холбогдох аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх.
  - 4.2.2 Объект, үйл ажиллагааны ашиглалт, үйлчилгээний технологи, дүрэм, журам, зааврын бүрдлийг хангасан байх.
  - 4.2.3 Үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүгийн чадавхи, боловсон хүчин, техник тоног төхөөрөмжтэй байх.
- 4.3 Гэрчилгээ хүссэн өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гэрчилгээ олгох, эсхүл олгохоос татгалзах тухай шийдвэрийн аль нэгийг нь гаргана.
- 4.4 Шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 4.7-д заасан хугацааг 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно.

- 4.5 Төрийн захиргааны төв байгууллага нь гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хангахгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагад гэрчилгээ олгохоос татгалзаж байгааг бичгээр мэдэгдэнэ.
- 4.6 Ажлын хэсэг гэрчилгээ хүсэгчийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бааз, техник хангамжийн нөхцөл байдлыг шаардлагатай гэж үзвэл газар дээр нь хянан шалгана.
- 4.7 Объект, үйл ажиллагааны гэрчилгээний хугацаа:
- 4.7.1 Объектын гэрчилгээг 5 жил хүртэлх хугацаагаар олгоно. Объектын гэрчилгээний хүчинтэй хугацаанд объектын өмчлөгч солигдвол өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигч нь объектын гэрчилгээ шинээр хүссэн өргөдлийг зохих журмын дагуу ирүүлнэ.
- 4.7.2 Үйл ажиллагааны гэрчилгээг 3 жилээр олгоно.
- 4.7.3 Гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж хугацаа нь дууссанаар хүчингүйд тооцно.
- 4.7.4 Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын байнгын, орон тооны бус Ажлын хэсэг /цаашид ажлын хэсэг гэх/ гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргана.
- 4.8 Ажлын хэсэг нь өргөдөл гаргагчийн баримт бичгийн агуулга, бүрдэл, гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хангасан байдлыг ирүүлсэн дарааллын дагуу хянан үзэж, нягтлан шалгана.
- 4.9 Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн сайд Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.
- 4.10 Гэрчилгээний загварыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар батлах бөгөөд гэрчилгээнд объект, үйл ажиллагааны код, нэр, төрөл, хүчинтэй хугацаа, техникийн үзүүлэлтүүд, гэрчилгээний нөхцөл, шаардлага, олгосон байгууллага, эрх бүхий албан тушаалтны нэр, эзэмшигчийн нэр, хаяг дугаар, олгосон он, сар, өдөр бичигдэнэ.
- 4.11 Гэрчилгээг үйл ажиллагааны хариуцлагын даатгалын батламж эсхүл даатгалын хураамж төлсөн баримтыг үндэслэн олгоно.

**Тав. Гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг, гэрчилгээг сунгах**

- 5.1 Гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг.
- 5.1.1 Гэрчилгээ эзэмшигч нь зөвхөн гэрчилгээнд заасан үйл ажиллагааг эрхэлнэ.
- 5.1.2 Гэрчилгээ эзэмшигч нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах нөхцөл шаардлагыг биелүүлэх, хэрэв объектын үндсэн эд

анги, үйл ажиллагаанд өөрчлөлт орсон бол 30 хоногийн дотор төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдсэн байна.

5.1.3 Гэрчилгээний хүчинтэй хугацаанд объект, үйл ажиллагааны хэвийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж болох бүтэц, технологийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь энэ тухай төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

5.1.4 Энэ журмын 5.1.2-т заасан өөрчлөлтийг хийсэн бол гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг нэмж тусгах буюу шинээр гэрчилгээ олгоно. Шинээр гэрчилгээ олгох асуудлыг энэ журмын 4-р зүйлд заасан журмаар хянан шийдвэрлэнэ.

5.1.5 Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага нь төмөр замаар зуучилж тээвэрлүүлсэн ачааны төрөл, хэмжээний тайланг тээвэрлэгчээр баталгаажуулан, жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

## 5.2 Гэрчилгээг сунгах.

5.2.1 Гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргана. Өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана.

5.2.1.1 Зохих журмын дагуу гаргасан өргөдөл.

5.2.1.2 Гэрчилгээний эх хувь.

5.2.1.3 Гэрчилгээжүүлсэн объектын ашиглалт, үйл ажиллагааны тайлан /захиалагч байгууллагаас гаргасан тодорхойлолт, үйл ажиллагааны үр дүнг нотлох баримт бичиг, акт, фото зураг зэрэг болно/.

5.2.1.4 Гэрчилгээ авахаар бүрдүүлсэн материал болон мэдээлэлд орсон өөрчлөлтийн тухай мэдээлэл.

5.2.1.5 Харъяалах татварын байгууллагын тодорхойлолт.

5.2.1.6 Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт.

5.3 Гэрчилгээний хугацааг сунгуулах тухай өргөдлийг энэ журмын 5.2.1-т заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд гэрчилгээ шинээр олгох журмыг баримтална.

5.4 Гэрчилгээг сунгасан тухай бүртгэлийг гэрчилгээжүүлэлтийн сунгалтын хэсэгт тэмдэглэнэ.

**Зургаа. Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох,  
нөхөн олгох тухай**

- 6.1 Гэрчилгээний үйлчлэлийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ.
  - 6.1.1 Гэрчилгээний хугацаа, нөхцөл шаардлагыг зөрчсөн.
  - 6.1.2 Энэ журмын 5.1, 5.2 дахь заалтуудыг зөрчсөн.
  - 6.1.3 Гэрчилгээ эзэмшигчийн хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, байгууллагын эрх ашиг зөрчигдсөн.
- 6.2 Төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлэх санал гаргасны дагуу төрийн захиргааны төв байгууллага түдгэлзүүлэх эсэхийг хянан шийдвэрлэнэ.
- 6.3 Гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн зөрчлийг арилгасан талаар төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагчийн саналыг үндэслэж түүнийг сэргээнэ.
- 6.4 Гэрчилгээг дараах тохиолдолд хүчингүй болгоно.
  - 6.4.1 Гэрчилгээ эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан.
  - 6.4.2 Гэрчилгээний нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн нь тогтоогдсон.
  - 6.4.3 Гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй
  - 6.4.4 Гэрчилгээ авах хүсэлт гаргахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон.
  - 6.4.5 Гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан, бусдад шилжүүлсэн.
  - 6.4.6 Үйл ажиллагааны ажил, үйлчилгээнд тавигдах нөхцөл шаардлагыг хангаагүй.
- 6.5 Гэрчилгээг хүчингүй болгосон тухай мэдэгдлийг гэрчилгээ эзэмшигч, холбогдох суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 6.6 Гэрчилгээг нөхөн олгох үндэслэл:
  - 6.6.1. Гэрчилгээ эзэмшигч нь энэ журмын 7 дугаар зүйлд заасан гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сангаас авсан лавлагаа, хуулбар.
  - 6.6.2. Гэрчилгээг үрэгдүүлсэн тухай өдөр тутмын сонин, хэвлэлээр зарласан хэвлэлийн эх хувь.



- 6.7 Гэрчилгээ нөхөн олгох асуудлыг энэ журмын 6.6 дугаар заалтыг үндэслэн хянан шийдвэрлэнэ.

**Долоо. Мэдээллийн сан бүрдүүлэлт, хөтлөлт,  
хадгалалт, ашиглалт**

- 7.1 Гэрчилгээжүүлэлттэй холбоотой мэдээллийн санг хөтлөх, бүртгэх, хадгалах, ашиглуулах үйл ажиллагааг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан гүйцэтгэнэ.
- 7.2 Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан дараах мэдээллүүдийг агуулна.
- 7.2.1. Норм, нормативын баримт бичиг.
- 7.2.2. Гэрчилгээжсэн объект.
- 7.2.3. Гэрчилгээжсэн үйл ажиллагаа.
- 7.2.4. Объектын дугаар, ангилал, төрөл.
- 7.2.5. Хүний нөөцийн мэдээлэл.
- 7.3 Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг гэрчилгээ олгох тухай тушаал гарсны дараа болон хяналт шалгалтын үр дүнг үндэслэн тухай бүр баяжуулна.
- 7.4 Холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцад хамаарахаас бусад мэдээллийг салбарын мэдээллийн сангийн цахим хуудсанд нээлттэй байршуулна.
- 7.5 Гэрчилгээжүүлэлттэй холбоотой баримт бичгийг төрийн захиргааны төв байгууллагад архивын нэгж болгон хадгална.
- 7.6 Салбарын мэдээллийн санд төвлөрсөн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглах үйл ажиллагааг Архивын тухай хуулиар зохицуулна.

**Найм. Хяналт**

- 8.1 Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрчилгээжүүлэлтэд хамрагдсан объект, үйл ажиллагаанд хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавина.

“Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам”-ын нэгдүгээр хавсралт

**Төмөр замын аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага**

**Хүснэгт 1. Дагнасан хэрэглээний зам, талбай барих үйл ажиллагааны нөхцөл, шаардлага**

Байвал зохих инженер техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Үйл ажиллагаа эрхлэх ажлын байр, тоног төхөөрөмж
1. Төмөр замын замын инженер - 1, 2. Геодези, хайгуул зураг төслийн инженер - 1, 3. Замын техникч – 2,	Төмөр замын замын инженер нь 5 жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.	1. Механикч – 1, 2. Төмөр замын мэргэжлийн ажилтан - 5	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх	Дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар, арчлалтын үйл ажиллагааг 3 жил зөрчил, дутагдалгүй гүйцэтгэсэн;	<ul style="list-style-type: none"> <li>- Багаж, тоног төхөөрөмж хадгалах талбай, агуулахтай байх,</li> <li>- Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих багаж, хэрэгсэлтэй байх,</li> <li>- Цахилгаан болон хийн гагнуурын аппарат,</li> <li>- Замын индүү,</li> <li>- Усалгааны машин,</li> <li>- Авто самосвал,</li> <li>- Экскаватор,</li> <li>- Грейдер,</li> <li>- Замын домкрат,</li> <li>- цахилгаан чигжүүр,</li> <li>- цахилгаан үүсгүүр,</li> <li>- замын чиг татагч</li> </ul>

**Хүснэгт 2. Дагнасан хэрэглээний зам, талбайд ачих, буулгах үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага**

Байвал зохих инженер техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Аж ахуйн нэгжийн эзэмшлийн байр, тоног төхөөрөмж
1. Тээвэр зохион байгуулалтын инженер - 1	Мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.	1. Агуулах, талбайн эрхлэгч – 1, 2. Оосорлогч – 2, 3. Кранчин – 1, 4. Дохиочин -1	Мэргэжлийн үнэмлэхтэй байх.		<ul style="list-style-type: none"> <li>- Зориулалтын амралтын талбайтай байх, ажил, байр</li> <li>- Кран</li> <li>- Авто ачигч</li> <li>- Аюулгүй ажиллагааны хувцас хэрэгсэл,</li> <li>- Хатуу тооцоот багаж хэрэгслийн байр, савтай байх.</li> </ul>

Хүснэгт 3. Дагнасан хэрэглээний замд сэлгээний ажил гүйцэтгэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага

Байвал зохих инженер техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсдад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
<p>1. Тээвэр зохион байгуулалтын инженер – 1,</p>	<p>Мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.</p>	<p>1. Найруулагч - 2, 2. Туслах найруулагч - 2, 3. Машинч – 2, 4. Туслах машинч – 2.</p>	<p>Мэргэжлийн үнэмлэхтэй байх.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сэлгээний зүтгүүрийн объектын гэрчилгээ</li> <li>- Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх аюулгүй байдлын гэрчилгээ эсхүл зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ хийлгэх гэрээтэй байх,</li> <li>- Сэлгээний ажлын заавар</li> </ul>	<p>Сэлгээний бригадын амрах байртай байх, Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Радио станц,</li> <li>- Албан яриа бичлэгийн төхөөрөмж,</li> <li>- Хатуу тооцоот багаж хэрэгсэл.</li> </ul>

Хүснэгт 4. Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага

Байвал зохих инженерийн техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
<p>1. Зүтгүүрийн инженер – 2 .</p>	<p>Төмөр замын их, дээд сургуулийг зүтгүүрийн инженер мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэг цолтой дүүргэсэн, мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.</p>	<p>1. Техникийн үйлчилгээний ажилтан-4, 2. Гагнуурчин-1</p>	<p>1-ээс доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, мэргэжлийн диплом, үнэмлэхтэй эсхүл мэргэжлийн комисст шалгалт өгсөн байх.</p>	<p>Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ хийх технологийн горим</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зориулалттын ажил, амралтын байртай байх,</li> <li>- Техник үзлэг, үйлчилгээ, засвар гүйцэтгэх зориулалтын засварын замтай байх,</li> <li>- Нөөц болон нэн шаардлагатай сэлбэг, материал, хатуу тооцоот багаж хэрэгслийг хадгалах байртай байх,</li> </ul> <p>Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага :</p> <ul style="list-style-type: none"> <li>- Кран,</li> <li>- Гагнуурын хэрэгсэл,</li> <li>- Багаж хэрэгсэл,</li> <li>- Нөөц сэлбэг,</li> <li>- Зэхэлтийн тоног төхөөрөмж</li> </ul>

Хүснэгт 5. Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага

Байвал зохих инженерийн техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
1. Вагоны инженер – 2	Төмөр замын их, дээд сургуулийг вагоны инженер мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэг цолтой дүүргэсэн, мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.	1. Техник үйлчилгээний ажилтан-4, 2. Гагнуурчин-1	1-ээс доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, мэргэжлийн диплом, үнэмлэхтэй эсхүл мэргэжлийн комисст шалгалт өгсөн байх.	Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ хийх технологийн горим	<ul style="list-style-type: none"> <li>- Зориулалттын ажил, амралтын байртай байх,</li> <li>- Техник үзлэг, үйлчилгээ, засвар гүйцэтгэх зориулалтын засварын замтай байх,</li> <li>- Нөөц болон нэн шаардлагатай сэлбэг, материал, хатуу тооцоот багаж хэрэгслийг хадгалах байртай байх,</li> </ul> <p>Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Кран,</li> <li>- Гагнуурын хэрэгсэл,</li> <li>- Багаж хэрэгсэл,</li> <li>- Нөөц сэлбэг,</li> <li>- Зэхэлтийн тоног төхөөрөмж</li> </ul>

Хүснэгт 6. Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага

Зайлшгүй байх мэргэжилтэн, тэдгээрийн тоо	Ажлын туршлага	Мэргэжилтэнд тавигдах шаардлага	Ажил үйлчилгээнд тавих суурь нөхцөл	Ажлын байранд тавигдах шаардлага	Тавигдах бусад шаардлага
Тээврийн мэргэжилтэн – 2, санхүүгийн мэргэжилтэн – 1,	Тээврийн мэргэжилтэн нь мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш жил ажилласан байх	Тээврийн мэргэжилтэн нар нь Төмөр замын тээвэр зохион байгуулалтын удирдлага эсхүл тээвэр логистикийн удирдлагын чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэргийн мэргэжлийн дипломтой байх, нэгээс доошгүй мэргэжилтэн нь тээвэр зуучлалын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх	Үйл ажиллагааны гэрчилгээ олгосноос эсхүл сүүлийн жилийн тайлан ирүүлснээс хойш дараагийн тайлан ирүүлэх хугацаанд 10 вагон аас эсхүл 20 футийн чингэлэгт дүйцүүлсэн нэгж /TEU/-ээс доошгүй ачаа төмөр замаар зуучилсан байх	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай 25м <sup>2</sup> - аас доошгүй талбай бүхий ажлын байртай байх.	Төмөр замаар зуучилсан ачааны тайланг журмын хоёрдугаар хавсралтын дагуу тээвэрлэгчээр баталгаажуулан Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зам, тээврийн хяналтын нэгжид журамд заасан хугацаанд тайлагнах.

**Хүснэгт 7. Хатуу тооцоот багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага**

Байвал зохих инженерийн техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
<p>1. инженер-2 2. Чанар хэмжилтийн инженер-1</p>	<p>Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер</p>	<p>1. Токарьчин 2. Халуун төмөрчин 3. Мужаан 4. Хэвлэгч 5. Цутгуурчин 6. Гагнуурчин</p>	<p>Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх.</p>		<p>Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын ажлын байртай байх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэлийн байр</li> <li>- Хадгалах склад</li> <li>- Суурь машины цех</li> <li>- Халуун төмрийн цех</li> <li>- Механик цех</li> </ul> <p>Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага :</p> <ul style="list-style-type: none"> <li>- Токарийн суурь машин</li> <li>- Цахилгаан</li> <li>- Компютер</li> <li>- Шалгах, турших багаж тоног төхөөрөмж /Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан байх/</li> <li>- Гагнуурын аппарат ( цахилгаан, хийн)</li> </ul>



**Хүснэгт 8. Төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны байгууламжийн засвар, техникийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага**

Байвал зохих инженерийн техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
<p>1. Автомат, телемеханикийн инженер 2 /аль нэг нь мэргэшсэн инженер байх/ 2. Холбооны инженер-1.</p>	<p>Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер</p>	<p>1. Механик – 2 2. Холбооны техникч -1 3. Монтёр-3</p>	<p>Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх.</p>		<p>Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай ажлын байртай байх;  Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага : - Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих хэрэгсэл - Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан багаж хэрэгсэл</p>

**Хүснэгт 9. Төмөр замын зураг төсөл боловсруулах, түүнд хяналт тавих үйл ажиллагааны нөхцөл, шаардлага**

Байвал зохих инженерийн техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсдад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
1. Төмөр замын замын инженер -1, 2. Төмөр замын дохиололын инженер-1 3. Геодезийн инженер -1	Төмөр замын инженерийн аль нэг нь зураг төслийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх	1. Зургийн техникч-2	Мэргэжлийн үнэмлэхтэй байх	Гүйцэтгэсэн ажлын талаарх захиалагч байгууллагын тодорхойлолт	Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: - Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих хэрэгсэл, - Зураг, тооцооны программ хангамж, түүнийг боловсруулах компьютерийн техник хангамжтай байх,

**Хүснэгт 10. Дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар арчлалт гүйцэтгэх үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага**

Байвал зохих инженерийн техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
1. Төмөр замын замын инженер -1	5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер	1. Замын техникч - 2 2. Замын мэргэжлийн ажилтан - 4	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх	-	Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: - Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих хэрэгсэл, - Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан багаж хэрэгсэлтэй байх,

“Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам”-ын хоёрдугаар хавсралт

Төмөр замаар зуучлан тээвэрлүүлсэн ачааны жилийн тайлан

№	Төмөр замаар ачаа зуучилж тээвэрлүүлсэн хугацаа, улирал	Илгээлтийн төрөл	Тоо хэмжээ, ш /20тн-ийн чингэлэгт дүйцүүлсэн нэгж/
1	I улирал	Вагон	
		Чингэлэг	
2	II улирал	Вагон	
		Чингэлэг	
3	III улирал	Вагон	
		Чингэлэг	
4	IV улирал	Вагон	
		Чингэлэг	

Мэдээ гаргасан: /төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуйн нэгж байгууллагын холбогдох ажилтны овог нэр, албан тушаал, гарын үсэг, тамга тэмдэг/

Мэдээг хянасан: /тээвэрлэгч байгууллагын холбогдох ажилтны овог нэр, албан тушаал, гарын үсэг, тамга тэмдэг/